

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Д. Маам

**МАОГИЙНХНЫ ЗӨВЛӨЛТИЙН ЭСРЭГ ҮЗЭЛ БОЛ
СОЦИАЛИЗМ, КОММУНИЗМЫН ЭСРЭГ ҮЗЭЛ МӨН**

«Орос орны үлгэр дууриал нь орон бүхний...алсын биш зайлшгүй ирээдүйн чухал үйл хэргийг одоогийн түүхэн үед илтгэн харуулж байна»¹ гэж В. И. Ленин бүр 1919 онд сод билгүүнээр заасан билээ. 1917 онд Орос оронд ялсан аугаа их социалист хувьсгалын үзэл санааны шууд нөлөөгөөр Европ, Ази, Латин Америкийн нилээд олон оронд социалист хувьсгал ялж дэлхийн социалист систем бүрэлдэн тогтоод бас Ази, Африкийн тусгаар тогтносон хэд хэдэн орон социалист хөгжлийн замыг сонгон авч байгаа нь манай эрин үеийн үндсэн агуулга бол калитализмаас социализмд шилжих шилжилт мөн болохыг бодит амьдралаар нотолж байна.

Ийм учраас орчин үеийн гол зөрчлийг хэрхэн ойлгож, орчин үеийн хувьсгалт гол гурван хүчний тэмцлийг зүй ёсоор манлайлан яваа Зөвлөлт Холбоот Улсад яаж хандаж байгаагаар тухайн улс орны анги, нам, засгийн газрын олон улсын бодлого, тэднээс улс үндэстнийг нийгмийн дэвшил хөгжлийн замаар урагшлуулах үйлсэд оруулах хувь нэмэр тодорхойлогдож байна.

Зөвлөлтийн эсрэг маоизмын урсгалыг үндэслэсэн Мао Цзэдун өөрөө «Октябрийн хувьсгалын дараа аль ч орны засгийн газар ЗХУ-тай найрамдалтай аж төрөхөөс татгалзвал гагцхүү өөрийн орны ард түмний жинхэнэ эрх ашигт хохирол учруулах болно»² гэж орос оронд Октябрийн хувьсгал ялсанаас хойш 40 жилийн дараа буюу 1951 онд хэлж байсан удаа бий.

«Зөвлөлүүд» гэдэг үг бол дэлхий дээр анх Шинжлэх ухааны социализм, коммунизмыг жинхэнэ бодит амьдрал болгон хувиргаж буй ажилчин, тариачны засгийн хэлбэр, бүхэл бүтэн ард түмний хамтлагийн нэр юм. Гэхдээ энэ үг өнөөдөр социализм, коммунизмын ялалт мандалтыг бүхэлд нь хамарсан маш өргөн утгатай томъёолол болов. Тийм ч учраас социализм, коммунизмыг дайсагнагчид гол цохилтоо дэлхийн социализм, энх тайван, бух хувьсгалт хүчний гол түшиг тулгуур болсон Зөвлөлт Холбоот Улс руу чиглүүлж иржээ. Ингэхлээр «антисоветизм» буюу зөвлөлтийн эсрэг үзлийг ганц орны хүрээгээр хязгаарлан ойлгож хэрхэвч болохгүй юм. Тэр чанараараа ч Зөвлөлтийн эсрэг үзэл нь социализм, коммунизм улс түмний эрх чөлөө, үндэсний тусгаар тогтнолыг дайсагнагч нийт хүчний нэгдэн сүлбэлдэх нийтлэг нэг хөрс шороо болж байна. Энэ үзэл санааг дэвэргэх явдалд сүүлийн хорь гаруй жилд Хятадын дээрэнгүй үзэлтний маоист бүлэг ихээхэн том үүрэг гүйцэтгэж, ирлээ Энэ нь маогийнхны нийгэм-улс төрийн үзэл санаа, хятадын нийгмийн өвөрмөц байдалтай шууд холбоотой юм. Одоо Зөвлөлтийг эсэргүүцэх үзэл, бодло-

1 В. И. Ленин. Зохиолын 41-р боть, 75-р тал.

2 «Правда», 1957. XI. 7.

го нь хятадын эрх баригчдыг империализмын хамгийн харгис хүчинтэй сүлбэлдэн ойлртуулах үндсэн шижим хэлхээ болж байна.

Коммунизмын эсрэг үзэл, түүний тодорхой илрэл болох зөвлөлтийн эсрэг хөрөнгөтний үзэл ба маогийнхны зөвлөлтийн эсрэг үзлийн хоорондын ялгаа нь капитализмын төлөөлөгчид зөвлөлтийн эсрэг үзлийг үеэ нэгэнт өнгөрөөж буй капитализмын зайлшгүй мөхөх түүхэн тавиланг хаацайлах зорилгодоо ашиглаж байгаа бол маогийнхан нь их хятадын жанжлан ноёрхох эрмэлзлэл, хятадын ноёрхлыг дэлхий дахинд тогтоох зорилгод ашиглахыг хичээж байгаад оршиж байна.

Хятадын их гүрний жанжлан ноёрхох дээрэнгүй үзэл, бүх нийтийн энх тайван, улс түмний аюулгүй байдалд заналхийлэгч Бээжингийн гадаад улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх замд ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнууд, тэдний энхийг эрхэмлэгч тууштай гадаад бодлого гол саад хориг болж байгаа юм. Маогийнхан зөвлөлтийн эсрэг үзлийг маоизмын гол бүрэлдэхүүн хэсэг болгож тавиад ЗХУ-ыг «Америкийн империализмаас ч илүү аюултай дайсан»³ гэж зарлахын хамтад, социалист хамтын нөхөрлөлийг задлан бутаргах тактикийн үүднээс зөвлөлтийн эсрэг суртал нэвтрүүлгээ «зөвхөн зөвлөлт-хятадын маргаантай» холбосон дүр үзүүлж, харин социалист бусад бүх орон, коммунист болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний бусад бүх отрядын талаар «ялгаатай хандах» нэн хортой бодлого явуулж байна. Ийнхүү Хятадын эрх баригчид хагалан бутаргах, хатган үймүүлэх чиг шугамаа олон улсын тавцанд Зөвлөлтийн эсрэг үзлийн хэлбэрээр хэрэгжүүлэх гэж эрмэлзэж байна.

Зөвлөлтийн эсрэг Бээжингийн эрх баригчдын чиг бодлого нь маоизмын ерөнхий хөгжлийн» тодорхой үе шатыг дамнин улам бүр илэрч чангарсаар, эдүгээ нэн аюултай цэгтээ тулж ирлээ. Энэ утгаар маоизмын «хөгжил» хувьсал нь уг чанартаа зөвлөлтийн эсрэг маоист үзлийн «хөгжил» хувьсал боллоо.

Зөвлөлтийн эсрэг маоист үзэл нь Хятад дахь хувьсгалт хөдөлгөөний замд тохиолдсон бэрхшээлийг Мао Цзэ-дун овжноор ашиглаж 1935 оны нэгдүгээр сард Хятадын чөлөөлөх армийн болон Коммунист намын удирдлагыг гартаа оруулмагц Коминтерны зөвлөмж, ЗХУКН-ын интернационалч тус дэмжлэг, хамтын ажиллагааг үл тоомсорлох зам руу ХКН-ыг түлхэн оруулах явууллагаар эхэлж, Мао Цзэдуны өөрийн санаачлагаар 1941—1945 онд явагдсан «Ажлын арга барилыг цэгцлэх кампанийн» явцад бойжиж торнисон юм гэж үзэх бүрэн үндэстэй билээ. Тэр үед Мао Цзэ-дун «марксизмыг хятадчилан», «ленинизмийг үл хэрэгсэх», «Марксыг Цинь Ши-хуантай⁴ гүүрлэн холбох» санаа бодлоо гаргаж ирсэн юм. Маогийн бүлэг «Ажлын арга барилыг цэгцлэх кампаниар» хятадын едий төдий интернационал коммунистуудын амь насыг бүрэлгэн сүйтгэхийн хамт намын олон түмний дотор зөвлөлтийн эсрэг үзлийн үрийг цацаж эхэлжээ. Мао их хятадын жанжлан ноёрхох төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ЗХУ-ыг саад болох гол хүч гэж үзээд түүнийг аль болохоор сулруулах

3 «Жэньминь жибао», 1977. XI. I. «Мао Цзэдуны гурван ертөнцийн онол бол марксизм-ленинизмд оруулсан аугаа их хувь нэмэр мөн» хөтөлбөр өгүүллийг үзнэ үү.

4 Цинь Шихуан-Цинь улсын эзэн хаан Ин Чжэн (МЭӨ 259 --210)-ийг хэлж байна. Ин Чжэн дайнч хэрцгийгээрээ хятадын түүхэнд зард гарчээ. Түүний харгис хаанчлалын үеэс «Фэншу Кэнжу» («ном шатааж, эрдэмтдийг амьдаар булшлах») нэрээр түүхнээ тэмдэглэгдсэн хэрэг явдал хамгийн их дуулиантай юм. Хятадын маоист удирдлага Цинь Ши-хуанг, жич түүний «фэншу кэнжу» - ыг сурталчилсаар ирлээ Жишээ: «Жиньминь жибао», 1974, VI. 4.

санаа бодолтой байсан нь баримтаар нотлогдож байгаа юм. Энэ нь ЗХУКН, Зөвлөлтийн ажилчин анги, нийт хөдөлмөрчдийн бат нэгдэл болон зөвлөлт төрийн үндэсний бодлогыг муучлан гутаах, бүр цаашилбал гитлерийн фашизмыг ялахад ЗХУ-ын хүч бололцоонд эргэлзэх байдлаар илэрч байв.

Үүний зэрэгцээгээр дорно зүгээс довтлох аюулыг зайлуулах зорилгоор милитарист Японы эсрэг тэмцлээ идэвхжүүлэхийг хүссэн ЗХУКН-ын хүсэлтийг Мао 1941 оны намар элдвээр шалтаглан няцаагаад Японы булаан эзлэгчдийг идэвхгүй эсэргүүцэх тактикийг ХКН-д тулган хүлээлгэж байжээ.

Гэтэл дэлхийн II дайн ЗХУ-ын баатарлаг ард түмэн, армийн болон Гитлерийн эсрэг эвслийн орны хийгээд фашизмын эсрэг бүх хүчний ялалтаар төгсч, улмаар 1949 онд Хятадад ардын хувьсгал ялсны үр дүнд ХКН-ын удирдлагад интернационалч-коммунистуудын байр суурь бэхжсэн явдал ЗХУ, социалист лагерийн бусад оронтой ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлсэн билээ. Тийм нөхцөлд Мао Цзэдун Зөвлөлтийн эсрэг үзлийнхээ тактикийг өөрчилж зүсээ хувиргахад хүрсэн байна. Хятадад ардын хувьсгал ялсны дараах эхний 10 жилд БНХАУ, ЗСБНХУ-тай ах дүүгийн хамтын ажиллагаагаа хөгжүүлж, түүний сэтгэл харамгүй тал бүрийн тусламжийг авсны ачаар эдийн засаг, соёлын салбарт үлэмж амжилт олж, урьд өмнө Хятадад байгаагүй аж үйлдвэрийн салбар-авто машин, трактор, радио техникийн болон батлан хамгаалахын зэрэг олон төрлийн үйлдвэр байгуулагдсан юм.

Мао Цзэ-дун «Хятадыг аж үйлдвэрийн орон болгон хувиргахын тулд бид ЗХУ-ын тэргүүний туршлагыг ул суурьтай судлах хэрэгтэй. ЗХУ дөч гаруй жил социализм байгуулж байгаа бөгөөд түүний туршлага бидний хувьд маш үнэтэй зүйл болж байна. Түүнээс өөр хэн бидэнд ийм олон чухал үйлдвэр завод төсөвлөн барь, төхөөрөмжилж өгөхөв дээ. АНУ уу? Аль эсвэл Англи уу? Үгүй ээ! Аль нь ч биш. Гагцхүү ЗХУ л үүнийг хийж байна. Учир юу вэ гэвэл тус улс социалист орон, манай холбоотой билээ»⁵ гэж хэлж байжээ. Гэвч энэ бол их гүрний дээрэнгүй эрмэлзлэлээ хэрэгжүүлэх материаллаг бааз бий болгоход зөвлөлтийн хүч хөрөнгө, нинжин сэтгэлт тусламжийг завшин ашиглах эрмэлзлэл, өөрийнхөө алсын хар санаат төлвлөгөөгөө нууж хаах гэсэн арга мэх байжээ.

Дээрх үгийг Дэлхийн II дайны өмнө Нанкины засгийн газрын дэргэд сууж байсан АНУ-ын ЭСЯ-ны ажилтанд Мао Цзэ-дуны андгайлан хэлж байсан үгтэй харьцуулахад Маогийн чухам санаа тодорхой харагдах болно. Үүнд «Хувьсгал ялсны дараа Хятад улс ЗХУ-тай нөхөрлөхгүй, зөвлөлт орныг дуурайж хөгжихгүй, харин бид Хятад-Америк хоёр их үндэстний хамтын ажиллагааг өрнүүлж, Америкийн ардчилсан түүхэн замналаар замнах болно»⁶ гэж хэлж байжээ. Тэр ч учраас Мао 1956 оны II сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны өргөтгөсөн бүгд хурал дээр зөвлөлтийн эсрэг үзэл нэвт шингэсэн «Арван их харилцаа» гэгч сэдвийг дэвшүүлж байжээ. Ийнхүү Мао Цзэ-дун улс төрийн талбарт гарсан цагаасаа эхлэн хятад орон төвлөн ноёрхох ёстой гэгч үхширмэл үзлийг хэлбэрэлтгүй баримталж ирсэн бөгөөд тэр үзлээ Зөвлөлтийн эсрэг хандлагаар улам бүр шатлан өргөжүүлсээр байжээ.

5 Тэр үед хятадын удирдагчдын баримталж бийсан хуурамч тактикийн талаар: Мао Цзэ-дун, избранные произведения, М., 1951, т. 3

С. Сергейчук, США и Китай, М., 1973, зэрэг номд үзнэ үү.

6 К. Е. Shewmaker, Americans and Chinese Communists. 1927--1945 New York London, 1971.

Мао Цзэдун хятадын дотоод, гадаад бодлогод Зөвлөлтийн эсрэг чиглэлийг шатлан гүнзгийрүүлэх ажиллагаагаа «онолын» үүднээс нотлох зорилгоор янз бүрийн хуурамч үндэслэл зохиож байв. Үүнд юуны өмнө Мао Цзэ-дуны тариачны онолыг хэлэх хэрэгтэй. Улс нийгмийн дотор болон олон улсын хэмжээнд ажилчин ангийн гол холбоотон тариачныг давамгайлж хувьсгалч хүч болгон ажилчин ангиас дээгүүр тавих эрмэлзлэлийн⁷ гол санаа нь бодит социализмыг болон зөвлөлтийг эсэргүүцэхэд оршиж байв. Коммунист, ажилчны намуудын 1951 оны Москвагийн зөвлөлгөөний үеэр Маогийн гаргаж ирсэн «Дорнодын салхи өрнөдийн салхийг давамгайлна» гэдэг үндсэрхэх, тивэрхэх үзэл бол хэрэг дээрээ түүний тариачны онолыг олон улсын амьдралд хэрэглэх гэсэн эрмэлзлэл байсан юм.

Хятадын удирдагчид ЗХУ, социалист бусад оронтой харилцаагаа хүйтрүүлсэн 60-аад оны эхэн үеэс ХКН-ын Төв хэвлэлийн хуудсаар «баян, ядуу үндэстний онол» гэгчийг сурталчилж «тосгоноор хотыг бүслүүлэхийг» уриалж байв. Түүнийхээ дараа маогийнхан «Зөвлөлт болон хөгжингүй капиталист орны ажилчин анги нэгэнт хувьсгалт чанараа алдав»⁸ гэж зарлаад ядуу нь ядуудаа туслан «өөрийн хүчинд тулгуурлах явдал» орчин үеийн эдийн засгийн харилцааны шинэ хэлбэр болон бүрэлдэж байна»⁹ гэж итгүүлэхийг оролдож эхлэсэн юм. Энэхүү «үндэслэл» нь дэлхий дахины үндсэн гол зөрчил болон хүчний харьцааны асуудлаар 60-аад онд олон улсын коммунист хөдөлгөөний жанжин шугамын эсрэг сөргүүлж тавьсан маогийнхны «завсрын бүсний «онол» гэгчийн бүрэлдэхүүн хэсэг болж байв.

Харин 70-аад оноос эхлээд Бээжингийн эрх баригчид «Зөвлөлт нийгмийн шинж чанар өөрчлөгдөн социал-империализм» боллоо гэдэг томъёолол дэвшүүлэв. Үүнийгээ улам гүнзгийрүүлж ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн эсрэг «гурав дахь ертөнцийг» хандуулах, жанжлан ноёрхох стратегийн зорилгоо хэрэгжүүлэхэд ашиглаж болох хань хамсаатан олж авахын тулд маогийнхан «хоёр хэт их гүрэн» гэдэг номлолоо гаргаж ирэв.

Энэ нь Хятадын эрх баригчид жанжлан ноёрхох эрмэлзлэлээ хэрэгжүүлэх, юуны өмнө ЗХУ-ыг эсэргүүцэхэд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг буурьтай хүч болохгүй гэдгийг ойлгож «хоёрдугаар завсрын бүсний» орнууд, тухайлбал Канад, Япон, Англи, Франц зэрэг империалист гүрнийг гол холбоотон болгох тактикт шилжин орсныг харуулж байна. 1972 оны сүүлээр «Хунци» сэтгүүлд нийтэлсэн хөтөлбөр өгүүлэлд: «социалист орнууд (Хятад, Албани хоёрыг хэлж байгаа юм-зохиогч) хоёр хэт их гүрэн ЗХУ, АНУ-ын хооронд өргөн уудам завсрын бүс оршиж байна. Хэт их гүрнүүдийн жанжлалын эсрэг тэмцэл нь энэ завсрын бүсний улс гүрэн, ард түмний эрх ашгийг нэгтгэж байгаа юм» гэж бичиж байв. Ингэж хятадын удирдлага маоист үзэл суртлын гол бүрэлдэхүүн хэсэг болсон зөвлөлтийн эсрэг үзэл, ЗХУ-ыг дайсагнах бодлогоо хэрэгжүүлэхийн тулд олон улсын империализмтай цэрэг-эдийн засгийн талаар хамтран ажиллах явдлыг «Онолын» хэлээр зөвтгөх гэх оролдож ирлээ. Ингэж ЗХУКН-ын XXIV их хурал дээр Л. И. Брежневийн тэмдэглэснээр 60-аад оны сүүл 70-аад оны эхнээс БНХАУ-ын гадаад бодлого шууд пролетарийн интернационализмтай холбоогоо тасалж ангийн социалист агуулгаа бүрмөсөн алдсан байна.

7 Мао Цзэдун, «Түүвэр зохиол» (хятад хэлээр), Харбин, 1948 он, 414-р тал.

«Маогийн тариачны онолын» гол санааг мөн номын 319, 333-р талд үзнэ үү.

8 "Peking Review" 1965, № 10, p. 26.

9 Мөн тэнд.

Зөвлөлтийн эсрэг маоист үзлийн хувьслыг доорхи таван үндсэн шатанд хувааж болох юм.

Нэгдүгээр шат (50-иад оны сүүлээс 60-аад оны дунд үе). Энэ үеийн эхэнд хятадын удирдагчид дайн энх тайван, социалист хувьсгалын тухай асуудлаар марксизм-ленинизмын эсрэг балмад үзэл бодлогоо илт тунхаглан түүнийгээ олон улсын коммунист хөдөлгөөнд нялзаах гэж илэрхий оролдов. Мао Цзэ-дун коммунист-ажилчны намуудын Москвагийн зөвлөлгөөн дээр «Цөмийн дайнд хүн төрөлхтний тэн хагас устаж болох боловч империализм сөнөж, социализм даян дэлхийд ялна. Коммунистууд энэ хэтийн төлөвийг барьж ажиллах ёстой»¹⁰ гэж шууд мэдэгдээд түүний эрхэм дээд эрмэлзлэл бол дайн ба хүчирхийлэл мөн»¹¹ гэдгийг зарлав.

Зөвлөлтийн эсрэг маоист үзлийн I шатны эхэн үеийн онцлог гэвэл маогийнхан хятад-зөвлөлтийн найрамдалт харилцааг сулруулах, ЗХУ-ын нэр хүндийг гутаах бэлтгэл ажлыг далдуур хийж, ЗХУКН-ын эсрэг маргаан дэгдээх ажлыг голчлон анхаарч, түүнийгээ хоёр орны харилцааны хүрээнд явуулж байв.

Хоёрдугаар шат (1966—1968 он), Хятадад Маогийн цэрэг-хүнд суртлын дэглэм тогтоосон «соёлын хувьсгал» гэгч нь зөвлөлтийн эсрэг үзлийг Хятадын удирдагчдын зөвхөн дотоод төдийгүй гадаад бодлогын бүрдэл болгон дэвшүүлж ямар ч хаалт халхавчгүйгээр илэрхий явуулах үүд хаалгыг нээж өгөв. Тэгээд ч Маогийн улаан хамгаалагчид «зөвлөлтийн хүмүүсийн шөрмөсийг сугалж, цусыг ханаж Кремл дээр маогийн тугийг хатгаж, Москвагийн улаан талбайд дорно зүгийн улаан нарыг мандуулна» гэж хашгиралдаж эхлэсэн юм.

Энэхүү II шатан дахь зөвлөлтийг улайм цайм дайсагнах маогийнхны жигшүүрт ажиллагааны эрч хүч нь дэлхийн империалист хүчинтэй ойртон түншлэх зам гүүрийг засах бээжингийн эрх баригчдын эрмэлзлэлээр тодорхойлогдож байв.

Гуравдугаар шатанд (1969— 1973), маогийнхан «соёлын хувьсгалын тарьсан үр тариаг» хурааж, ЗХУ-ын эсрэг чиг шугамыг гадаад бодлогынхоо гол чиглэл болгон зарлаж тэр нь зөвлөлтийн хил дээр өдүүлсэн цуст өдөөн хатгалгаар батлагдав.

Ийнхүү дэлхийн социализм, ЗХУ-ын талаар ХКН-ын VII их хурлаас (1956) батлан гаргасан намын жанжин шугамыг маогийнхан албан ёсоор өөрчилсөн юм, ХКН-ын VIII их хурлын шийдвэрт: «БНХАУ-ын гадаад бодлогын тэргүүн зорилт бол ЗХУ, дэлхийн социалист системийн бусад бүх оронтой найрамдлаа цаашид бэхжүүлэх явдал мөн»¹² гэж заасан бол ХКН-ын IX их хуралд тавьж хэлэлцүүлсэн тайлан илтгэлдээ Линь Бяо дэлхийн гуравдугаар дайн «. ревизионизмыг бутниргэх хувьсгалд даян дэлхийн хүн ардыг дуудан босгоно» гэж уриалж байв.¹³

Энэ шатанд маогийнхан «социал-империализм» гэдэг сэдвээ улам гүнзгийрүүлж, ЗХУ-д капитализм сэргэж байгаа тухай гүтгэлгийн өргөн кампани өрнүүлж, Хятад улс улс төр, эдийн засгийн талаар капиталист ертөнцийг түшиглэн бараадах практик алхмаа хийж эхэлсэн юм. Ингээд 1973 онд хятадын гадаад худалдаанд капиталист орнууд 79 хувь эз-

10 Мао Цзэ-дун сысян ваньсуй. (Мао Цзэдуны үзэл санаа мандтугай). Бээжин 1967 он.

11 «О чем умалчивают в Пекине». М., 1972, с. 21.

12 «Материалы всекитайского VIII съезда КПК», М., «политиздат», 1956.

13 Линь Бяо, ХКН-ын бүх хятадын IX их хурлын тайлан, Бээжин, 1969 он (хятад хэлээр).

лэх болж харин социалист орнуудын эзэлж байсан хувь 21% болтол буурч АНУ-тай ойртон сүлбэлдэх ажил улам идэвхжжээ.

Дөрөвдүгээр шат нь 1973 оны 8-р сард хуралдсан ХКН-ын X их хурлаас 1977 оны 8-р сард хуралдсан XI их хурал хүртлэх хугацааг хамарч байна. ХКН-ын X их хурлын тайлан илтгэлд «Зөвлөлтийн ревизионизмын эрх баригч бүлэглэл ... капитализмыг сэргээж, фашист дарангуйлмыг хэрэгжүүлэн бүх үндэстний улс түмнийг боолчиллоо»¹⁴ гэж гүжирдэн гүтгэжээ. Маогийнхан зөвлөлтийг үзэн ядах үзэл санааг хятадад болон бусад газар оронд дэвэргэхийн тулд ЗХУ-ыг «ревизионизмаас» социал-империализм», социал-империализмаас «фашист дэглэмийг хэрэгжүүлсэн» улс орон мэт болгож хувиргав. Тэгэхдээ ЗХУ-ыг «Хоёр хэт их гүрэн гэдэг нэр томъёогоор АНУ-тай адилтган тавих нь АНУ болон өрнөдийн бусад капиталист оронтой ойртоход нь тааламж муутай болохоор тэднээс ЗХУ-ыг онцлон ялгахын тулд «фашист дэглэмтэй» орон «Хятадын гол дайсан» гэдэг чангаруулсан шинэ томъёо зохиожээ.

Чжоу Энх-лай Америкийн хэсэг хятад судлагчидтай ярилцахдаа ЗХУ бол «Хаант Оросоос ч илүү хаант улс, хуучин колоничлогчдоос ч илүүгээр колоничлогч улс юм» гэж хэлж байв. Түүгээр ч барахгүй Америкийн империализмыг Энэтхэг-хятадад ялагдсаны дараа хятадын удирдагчид ЗХУ-ыг «дайны хамгийн аюултай гал голомт»¹⁵ гэж зарлаад түүнийг эсэргүүцэхийн тулд хятад тэргүүтэй дэлхий дахины өргөн фронт байгуулахыг уриалж эхэллээ. Маогийнхны зөвлөлтийн эсрэг суртал ухуулгын кампани яаж гаарч байсныг харуулсан зарим нэг баримтыг дурдахад 1973 онд ХКН-ын Төв хэвлэл зөвхөн хоёр сонин, «Хунци» сэтгүүлд Зөвлөлтийг гүтгэж муучилсан 800 өгүүлэл нийтлэгдсэн бол 1974 онд тэр нь даруй 1700 болж бараг хоёр дахин өсчээ. Дараахь жилийн эхний 6 сард ЗХУ-ыг дайрч давшилсан мэдээ материал 1100 гаруй хэвлэж байв. Зөвлөлтийн эсрэг үзлээр хүмүүжсэн, энэ үзлийг тараагч «онолчдын отряд» гэгчид зарим мэдээ сэлтэд дурдсанаар хэдэн сая за луучууд хамрагдан ажиллаж байна. Зөвлөлтийн эсрэг маоист үзэл хувьсч чангарч ирсний дөрөв дэх шатны нэг онцлог бол Мао үхсэн боловч түүний социализмын эсрэг, Зөвлөлтийн эсрэг үзэл санааг Хуа Го-фэны бүлэг өвлөн авч хятадын жанжлан ноёрхох шунахайран эзлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хоёр системийн хоорондын зөрчил тэмцлийг хурцатгах гол нэг хэрэглүүр болгон хэрэглэх гэж онцгой чармайж буй явдал юм.

Тавдугаар шат. Үргэлж өсч ширүүсч байгаа зөвлөлтийн эсрэг хятадын удирдагчдын чиг шугамын хувьслын тав дахь шат нь ХКН-ын XI их хурлаар (1977) эхлэсэн гэж үзэж болох билээ. Хятадын маоист шинэ удирдлага зөвлөлтийн эсрэг үзлээ цэрэг дайны хэнээрхэл империалист харгис хүчинтэй сүлбэлдэн нөхцөх «гурван ертөнцийн онол» гэгч харгис томъёоллоор бататгах гэж оролдож байна. Ийнхүү зөвлөлтийн эсрэг империалист үзэл, зөвлөлтийн эсрэг маоист үзэл хоёр нэгдэн нийлэх явдал бодит байдал болж хувирав.

Маогийнхан зөвлөлтийн эсрэг үзлийнхээ мөн чанарыг нуухын тулд тэр нь зөвхөн Хятад-Зөвлөлтийн харилцаанд хамаарагдаж байгаа зүйл мэтээр үнэмшүүлэхийг хичээж байгаа нь үндсээрээ хуурамч бөгөөд алсын хорон санаатай заль мэх юм. Яагаад гэвэл зөвлөлтийн эсрэг алив үзэл бол социализм, коммунизмын эсрэг, улс түмний эрх чөлөө, үндэсний тусгаар тогтнолын эсрэг чиглэсэн бурангуй харгис үзэл санаа байдаг нь нийтэд илэрхий билээ. Маоизм бол уг чанартаа марксизм-ленинизм үнд-

14 Чжоу Энх-лай, ХКН-ын Бүх Хятадын X их хурлын тайлан, Бээжин, 1973 он (Хятадаар)

15 "Unzere Zeit" 973 III 9.

сээрээ эсрэг юм. Зөвлөлт Холбоот Улс өнөөдөр ленинизмийн эх орон, хувьсгалт марксизм, шинжлэх ухааны коммунизмыг бодит амьдрал болгон хувиргаж байгаа учраас зөвлөлтийн эсрэг социализм гэж байх үндэсгүйг ах дүү коммунист, ажилчны намын удирдагчид нэг бус удаа онцлон заасан юм. Тийм болохоор зөвлөлтийг эсэргүүцэх үзлийг төрийнхөө гадаад бодлогын чиг шугамын үндэс болгон тунхагласан хирнээ социализм байгуулж байгаа тийм нам, орон гэж байх ёсгүй билээ.

Марксизм-ленинизм, социализмын нэрээр маогийнхан халхавч хийж байгаагийн учир нь нэг талаар дэлхий дахины хөдөлмөрчдийн аугаа их интернационалч сургаал марксизм-ленинизмийн хувьсгалжуулагч нөлөө ихэд дэлгэрч түүний ач тусыг гүнээ ухамсарлан ойлгогсдын хүрээ өдрөөс өдөрт, тивээс тивд өргөжсөн, нөгөө талаар маоизмын нэр хүнд туйлын бага, тэгээд ч түүнд эргэлзэх сэжиглэх явдал маогийн талынхны дотор ч цаг үргэлж хүчтэй болсоор байгаад оршиж байна.

Маоизмын буюу Хятадын эрх баригчдын социал-шовинист үзэл бодлын гол зорилго нь эцсийн эцэст хятадын ноёрхлыг дэлхий дахинд тогтоох, одоо дэлхийн хувьсгалт гол гурван хүчний дотор ЗХУ-ын эзэлж байгаа нэр хүндтэй байр суурийг булааж авахад чиглэгдэж байгаа юм.

Империализмын тухай маогийнхны төсөөлөл нь цаг ямагт маоизмын аминч явцуу, их гүрний дээрэнгүй эрх ашгийн тусгал болсоор ирлээ. Тухайлбал, милитарист Япон Хятадыг халдан түрэмгийлж байсан 30—40 өөд оны үед маогийнхан Зөвхөн японы милитаризм, түүний булаан түрэмгийлэх гадаад бодлогыг л «империализм» гэж үзэж байв. Харин АНУ-ыг бол 60-аад оны хагас хүртэл БНХАУ-ыг илэрхий дайсагнах бодлого явуулж байсан үед нь Хятадын удирдагчид түүнийг «империализм» гэж нэрлэж байлаа. Тэгвэл одоо Хятадын жанжлалын бодлогод гол хориг саад болж байгаа ЗХУ-ыг маогийнхан хамгийн аюултай «социал-империализм» гэж зарлаж байна. Иймэрхүү аргыг хятадын мили таристууд ч хэрэглэж байсан юм. Чан Кай-ши ЗХУ-ыг «улаан империализм» гэж нэрлээд тэр нь Америкийн империализм буюу «цагаан империализмаас» ч илүү аюултай гэж ухуулдаг байсан юм.

Зөвлөлтийн эсрэг үзлийг Хятадын дотоод, гадаад бодлогын үндэс болгон дахин тунхагласан ХКН-ын XI их хурал, БХАТХ-ын сүүлчийн чуулганы шийдвэр, сүүлийн үед Маогийн «онолын гол өв» болгон Бээжингийн сурталчилж байгаа «гурван ертөнцийн тухай онол» гэгч нь олон улсын харилцааны асуудалд ангийн байр сууринаас, үгүй ядаж империализмыг эсэргүүцэгч орчин үеийн гол хандлагын үүднээс хандах явдлыг бүрмөсөн таягдан хаяж, капиталист, социалист орнуудын анги, нийгмийн ялгааг устган, ажилчин анги, нийт дарлагдсан ангийг дарлагч анги-капиталист, монопольтнуудтай, колони байсан орнуудыг тэднийг ноёлж дарлаж байсан империалист гүрнүүдтэй нэг фронтод нэгдэж Зөвлөлтийн эсрэг, дэлхийн социалист хамтын нөхөрлөлийн эсрэг тэмцэх, империалистуудын дайн түрэмгийллийн бодлогыг хэрэгжүүлэхэд туслалцахыг уриалж байна. Хятадын одоогийн удирдагчдын маоист харгис төлөвлөгөөний шинэхэн жишээ нь энэ оны 8-р сарын 12-нд Бээжинд гарын үсэг зурж «жанжлалын эсрэг тэмцэх» тухай харилцан тохиролцсон «Япон-Хятадын энх тайван, найрамдын гэрээ» гэгчийн зөвлөлт болон социалист хамтын нөхөрлөлийн бүх орнуудын эсрэг үзэл санаа юм. Ийм учраас зөвлөлтийг эсэргүүцэх үзэл, дайсагнагч харгис маоизмын үзэл санаа, Хятадын эрх баригчдын дайнч балмад хэрцгий бодлогыг эрс шийдвэртэй тэмцэн няцаах явдал МАХН-ын Төв Хорооны бүгд хурал дээр МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хур-

лын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбалын тэмдэглэн хэлсэнээр «шударга хүн бүхний үүрэг, энх тайван, аюулгүй байдал, нийгмийн дэвшлийн төлөө тэмцэгч бүхний үүрэг» болж байна.

Д. Маам

МАОИСТСКИЙ АНТИСОВЕТИЗМ-ИДЕОЛОГИЯ, ВРАЖДЕБНАЯ СОЦИАЛИЗМУ И КОММУНИЗМУ

Резюме

Маоистский антисоветизм, будучи одной из разновидностей антикоммунизма, враждебен социализму и коммунизму, и служит своим инициатором своеобразным мостиком для смыкания с наиболее реакционными силами империализма.

В статье анализируется сущность антисоветизма маоистов, являющегося стержнем великодержавно-шовинистической политики китайских лидеров.

Если буржуазные представители пользуются антисоветизмом для маскировки истинного лица капиталистического мира, то с помощью оголтелого антисоветизма маоистское руководство Китая всячески старается реализовать свои гегемонистские планы в мировом масштабе, а общность этих двух разновидностей антикоммунизма заключается в борьбе против социализма, мирового коммунистического и рабочего движения и национально-освободительной борьбы народов Азии, Африки и Латинской Америки.

Как известно, в определенных периодах национально-освободительного и рабочего движения Китая, в частности, в первые годы существования КНР, маоисты неоднократно заявляли, что Советский Союз является авангардом мирового коммунистического и рабочего движения, опором борьбы всех трудящихся мира, а советский образ жизни есть символ будущего человечества и внешняя политика советского государства является живым примером служения в интересах угнетенных народов и т.д. Однако, как подчеркивает автор, эти заявления остались только на бумаге, так как они были типичной маоистской лицемерной тактикой, предпринятой для обмана общественного мнения с целью временного использования технико-экономической помощи Советского Союза и других социалистических стран.

Остановившись на основных моментах эволюции антисоветизма маоистов, автор делит его на пять этапов, подробно излагая содержание, характер, особенность, общие черты и взаимосвязи этих этапов. Автор выделяет следующие этапы:

первый этап-с конца 50-х гг. до середины 60-х гг.

второй этап-с 1966 г. по 1968 г.

третий этап-с 1969 г. по 1973 г.

четвертый этап-с августа 1973 г. по август 1977 г.

пятый этап-с августа 1977 г. до наших дней

В статье показывается, что эволюция маоистского антисоветизма отражает не только усиление узконационалистического эгоизма, но и про-

цесс постепенного сближения и блокирования маоистов с реакционными силами империализма.

Вопреки убеждению китайской пропаганды, антисоветизм китайского руководства не только направлен против СССР, но и направлен против мирового социализма, национально-освободительного движения и против всего прогрессивного человечества и представляет собой составную часть великодержавно-гегемонистской политики Пекина.

В заключении автор отмечает, что борьба против маоистского антисоветизма есть борьба против наиболее реакционных сил, представляющих серьезную угрозу для дела мира, безопасности и социального прогресса.